



ӨВӨРХАНГАЙ ЛЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 1/39

Хужирт сум

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: З.Цэцэгмаа (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Л.Цэдэв (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Б.Бямбасүрэн (Байгаль орчны Улсын хяналтын байцаагч)

Ц.Нямдорж (Газрын даамал)

Д.Мөнхбат ((Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Б.Пүрэвжав (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

С.Самдан (2 дугаар багийн иргэн - зөвшилцсөнөөр)

2. Дээрх журмын 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтад заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, зөвлөмж, дүгнэлтийг хуулийн хугацаанд багтаан ирүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (З.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622381079

D:Alban bichig;Zahiramj 2023